



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/146

Чингис хот

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн №13 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст /COVID-19/ халдварын нөхцөл байдалтай холбогдуулан Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд сунгасугай.

2. 2020 оны А/146 тоот захирамжийн үйлчлэлийг дээрх хугацаанд сунгасугай.

3. Тусгаарлах байрнаас гарсан иргэнийг 7 хоногийн хугацаанд Коронавируст /COVID-19/ халдвараар өвчлөөд эдгэрсэн иргэнийг эмнэлгээс гарсан өдрөөс хойш 28 хоногийн хугацаанд тухайн иргэний оршин суугаа Засаг захиргааны нэгж, багийн Засаг дарга, цагдаагийн хэсэг, сууц өмчлөгчдийн холбоо, сайн дурын ажилтнуудыг дайчлан хянаж ажиллахыг сумдын Засаг дарга, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай

4. Шинэ Коронавируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, тусгаарлах байранд ажиглалтад хамрагдах иргэдийн эрүүл мэндийг болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор тусгаарлах байрны 1 өрөөнд 1 хүн /1 гэр бүл/-ийг байршуулах байрыг бэлдэж бэлэн байдлыг хангахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Шуурхай штабын дарга дэд хурандаа Ж.Эрдэнэбат нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010475